ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 06 сарын 20 өдөр Дугаар А/105 Мандалговь

Гэрээ байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дугаар зүйлийн 34.1.1 дахь заалт, Засаг даргын тамгын газрын даргын 2017 оны А/63 тоот тушаалаар байгуулагдсан үнэлгээний хорооны дүгнэлтийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Аймгийн орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдэх “10 багийн Засаг даргыг унаажуулах” мотоцикл нийлүүлэх ажил /ДУОНӨГ/2017/00017/-ын гүйцэтгэгчээр “Өнө мөнх хайрхан” ХХК – ийг сонгон 17,800,000 /арван долоон сая найман мянга/ төгрөгөөр гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулсугай.

Хоёр. Техникийн тодорхойлолтын дагуу мотоцикл нийлүүлэх ажлыг чанарын өндөр түвшинд гүйцэтгэхийг “Өнө мөнх хайрхан” ХХК-ний гүйцэтгэх захирал /А.Мөнхбаяр/ -д үүрэг болгосугай.

Гурав. Дээрх байгууллагатай гэрээ байгуулж, бараа нийлүүлэлтэнд хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга /Н.Эрдэнэ-Очир/, Төрийн захиргаа удирдлагын хэлтсийн дарга /М.Цогзолмаа/ нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА О.ЧУЛУУНБАТ

0200278